

=

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"Хүдэр тохижилт" ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/13/НА-СТА-ОНА

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](http://www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум  
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитор: Б.Ундаръяа

Утас: 70376994 Цахим хаяг: [dalaivandarkhan@gmail.com](mailto:dalaivandarkhan@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УИХ	Улсын их хурал

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл ...	9
3.Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	10
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	11
3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	12
4. Аудитын тайлан .....	12
4.1 Ерөнхий зүйл .....	12
4.2 Дотоод хяналт .....	13
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
4.4. Материаллаг байдал.....	13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
5.1 Шилэн дансны мэдээлэл .....	14
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	14
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
8. Аудитын илрүүлэлт.....	15
8.1 Албан шаардлага .....	15
8.2 Зөвлөмж.....	15
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	18



“ХҮДЭР ТОХИЖИЛТ” ОНӨААТҮГ-ЫН  
ДАРГА Ж.ОДЖАРГАЛ ТАНАА

## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.15 № СЭА-2022/13-НА-СТА-ОНА  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хүдэр тохижилт” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Хүдэр тохижилт” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

СЭА-2022/13-НА-СТА-ОНА

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

				/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31		
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>	<b>9,000.31</b>	<b>1,210,795.72</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>9,000.31</b>	<b>1,210,795.72</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	9,000.31	46,831.56		
1.1.2	Дансны авлага				
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		1,163,964.16		
1.1.4	Бусад авлага				
1.1.6	Бараа материал				
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо				
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>				
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>				
1.2.1	Үндсэн хөрөнгө				
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>				
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>9,000.31</b>	<b>1,210,795.72</b>		
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>				
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>				
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>				
2.1.1.1	Дансны өглөг				
2.1.1.2	Цалингийн өглөг		36,623.24		
2.1.1.3	ААНОАТ өглөг	33,527.73			
2.1.1.4	НӨАТ өглөг	3,922,075.57	2,621,766.16		
2.1.1.5	ХХОАТ өглөг	1,359,532.26	-		
2.1.1.6	НДШ – ийн өглөг	357,575.93			
2.1.1.7	Урьдчилж орсон орлого		5,170,000.00		
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>5,672,711.49</b>	<b>7,828,789.40</b>		
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>				
2.1.2.1	Урт хугацаат зээл				
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/				
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>				
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>5,672,711.49</b>	<b>7,828,789.40</b>		
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>				
2.3.1	Өмч:-төрийн				
2.3.2	хувийн				
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(5,663,711.18)	(6,617,993.69)		
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>				
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>9,000.31</b>	<b>1,210,795.72</b>		

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	38,685,181.00	54,075,681.71
2	Борлуулалтын өртөг	166,287.00	-
<b>3</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>38,518,894.00</b>	<b>54,075,681.71</b>
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	38,183,616.63	55,063,488.39
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг ( алдагдал)		
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>	<b>335,277.37</b>	<b>(987,806.69)</b>
19	Орлогын татварын зардал	<b>33,527.73</b>	-
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>301,749.64</b>	<b>(987,806.69)</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>301,749.64</b>	<b>(987,806.69)</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>		
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Нэмж төлөгдсөн капитал	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>			(5,965,460.82)	(5,965,460.82)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
<b>Залруулсан үлдэгдэл</b>				
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			<b>335,277.37</b>	<b>335,277.37</b>
Өмчид гарсан өөрчлөлт				
Зарласан ногдол ашиг				
<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>			<b>(5,663,711.18)</b>	<b>(5,663,711.18)</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
<b>Залруулсан үлдэгдэл</b>				
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(987,806.69)	(987,806.69)
Зарласан ногдол ашиг				
<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>			<b>(6,617,993.69)</b>	<b>(6,617,993.69)</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

				/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31		
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
1.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>42,553,700.00</b>	<b>64,663,650.00</b>		
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	34,070,700.00	64,663,650.00		
	Татаас, санхүүжилтийн орлого				
	Бусад мөнгөн орлого	8,483,000.00	-		
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>42,856,364.69</b>	<b>64,625,818.46</b>		
	Ажиллагчдад төлсөн	22,805,085.00	28,340,788.30		
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	8,163,736.00	9,268,738.11		
	Бараа материал худалдан авахад төлсөн	431,700.00	-		
	Ашиглалтын зардалд төлсөн	1,749,115.00	390,660.00		
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,789,210.00	4,030,375.45		
	Хүүний төлбөрт төлсөн				
	Татварын байгууллагад төлсөн	5,785,178.69	10,927,106.45		
	Даатгалын төлбөрт төлсөн				
	Бусад мөнгөн зарлага	132,340.00	11,668,150.15		
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(302,664.69)</b>	<b>37,831.54</b>		
2	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>				
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>				
5	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(302,664.69)</b>	<b>37,831.54</b>		
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	311,665.00	9,000.31		
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,000.31	46,831.85		

## 2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Орлогын нийт дүн	63,284,650.00	54,075,700.00	9,208,950.00	85%
1.1	Цэвэр бохир ус	36,492,700.00	31,823,600.00	4,669,100.00	87%
1.2	Бусад ажил үйлчилгээ	13,029,300.00	11,462,400.00	1,566,900.00	88%
1.3	ЗГ-аас усны үнийн дэмжлэг	13,762,650.00	10,789,700.00	2,972,950.00	78%
2	Зардлын дүн	63,284,050.00	63,284,050.00	-	100%
2.1	Цалин хөлс	34,460,000.00	28,340,788.00	6,119,212.00	82%
2.2	НДШ	4,652,100.00	9,626,314.00	(4,974,214.00)	207%
2.3	Тээвэр шатахуун	3,800,000.00	4,027,830.00	(227,830.00)	106%
2.4	Гэрэл цахилгаан	1,342,228.00	390,660.00	951,568.00	29%
2.5	Урсгал засвар	2,000,000.00	3,840,000.00	(1,840,000.00)	192%
2.6	Албан томилолт	124,000.00	-	124,000.00	0%
2.7	Бичиг хэрэг	80,000.00	-	80,000.00	0%
2.8	Бараа ажил үйлчилгээний бусад	1,976,000.00	3,544,122.45	(1,568,122.45)	179%
2.9	НӨАТ	6,234,722.00	6,499,335.55	(264,613.55)	104%
2.10.	Гэрээгээр гүйцэтгэх хөрөнгө оруулалтын ажил	8,615,000.00	7,015,000.00	1,600,000.00	81%

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Хүдэр тохижилт” ОНӨААТҮГ нь “Сумын айл өрх, аж ахуйн нэгжүүдийг цэвэр усаар ханган нийлүүлэх” зорилт тавин ажиллаж байна.

Хүдэр тохижилт ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ус түгээх, усан сангийн үйл ажиллагаа эрхлэх,
- Орон нутгийн өмчит нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, ногоон байгууламж, авто зам, гүүр, гадаргуугийн болон хөрсний ус зайлуулах барилга байгууламжийн ашиглалт хамгаалалт, засвар үйлчилгээг гүйцэтгэх,
- Нийтийн үйлчилгээний чиглэлээр гэрэлтүүлэг, хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл хэрэгжүүлэх хамгаалах.

Тус аж ахуйн нэгжийг Хүдэр сумын ИТХ-аас “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар” хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд 100 хувь орон нутгийн өмчид харьяалагдаж байна.

#### 3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Хүдэр тохижилт” ОНӨААТҮГ нь Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор байгуулагдсан байна. Энэ нь Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд “Сум, дүүргийн Хурлын бүрэн эрх”, 18 дугаар зүйлийн 18.1.3 ж-д “Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, **дүрмийг батлах**”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ **орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих**” гэсэн заалттай нийцэж байна.

Тус байгууллагад Төлөөлөн удирдах зөвлөл байхгүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол,

мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,

- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Хүдэр тохижилт” ОНӨААТҮГ -ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9.0	46.8	37.8
Татвар, НДШ-ийн авлага		1,164.0	1,164.0
Бараа материал			
Үндсэн хөрөнгө			
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>9.0</b>	<b>1,210.8</b>	<b>1,201.8</b>
Өр төлбөр	5,639.2	7,828.8	2,189.6
Эздийн өмч	(5,630.2)	(6,618.0)	(987.8)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>9.0</b>	<b>1,210.8</b>	<b>1,201.8</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 37.8 мянган төгрөгөөр өссөн нь 64,663.6 мянган төгрөгийн орлого олж, 64,625.8 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Авлага данс 1,164.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь цалингаас суутгасан ХХОАТ-ыг илүү шилжүүлснээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 7,828.8 мянган төгрөг болж 2,189.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь засгийн газраас санхүүжүүлсэн усны төлбөрөөс 5,170.4 мянган төгрөгийг татварт тайлагналгүйгээр урьдчилж орсон орлогоор бүртгэсэнээс голлон шалтгаалсан байна.

Хуримтлагдсан ашиг (6,618.0) мянган төгрөг болж 987.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны алдагдал 987.8 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### 3.4. ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Хүдэр тохижилт” ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор “Хүдэр тохижилт” ОНӨААТҮГ-ын 2021 оны тодотгосон эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 63,284.6 мянган төгрөгөөр, нийт зардлыг 63,284.6 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 54,075.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 55,063.5 мянган төгрөгийн зардал гарган, 987.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл дараах эх үүсвэрээс бүрджээ. Үүнд:

- Аж ахуйн нэгж, байгууллагын усны орлого 31,823.6 мянган төгрөг,
- Засгийн газраас айл, өрхийн усны төлбөр 10,789.7 мянган төгрөг,
- Засварын ажил хөлс 10,407.3 мянган төгрөг,
- Бусад орлого 1,055.1 мянган төгрөг.

Нийт орлогын гүйцэтгэл 54,075.7 мянган төгрөг болж төлөвлөснөөс 9,208.9 төгрөг буюу 17.0 хувиар тасарсан нь 5,170.4 мянган төгрөгийн орлогыг урьдчилж орсон орлогоор бүртгэснээс шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 55,063.5 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 8,221.1 төгрөг буюу 15 хувиар бага байна.

## 4. Аудитын тайлан

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Хүдэр тохижилт” ОНӨААТҮГ-ын /цаашид “Хүдэр тохижилт” ОНӨААТҮГ гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллагын дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд өгсөн татвар, нийгмийн даатгалын өр төлбөртэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор «Au\_code»ОНА

Б.Ундаръяа, аудиторын туслах Ж.Сайнбилэг нар гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Хүдэр тохижилт” ОНӨААТҮГ” нь 2021 оны санхүүгийн тайланг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарт 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Дотоод хяналт**

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллага өөрийн онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг баримт боловсруулж мөрдөөгүй байна.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй хийгдээгүй байна.

#### **4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Хүдэр тохижилт” ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

#### **4.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 55,063.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 550.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 385.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 137 мэдээллийг хугацаанд нь, 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 5 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### **5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д *“Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх”* гэж заасны дагуу шагнал урамшуулал олгоогүй, зочин төлөөлөгч хүлээн авах болон бэлэг дурсгалын зардал гаргаагүй байна.

Харин төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэн батлаагүй байна.

## **6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 9,893.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 3,922.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	9,893.6	1	9,893.6	100
Зөвлөмж	3	3,922.0	2	3,922.0	66.6
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>13,815.6</b>	<b>3</b>	<b>13,815.6</b>	<b>75.0</b>

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 17,795.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 1,164.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага, 16,631.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

### 8.1 АЛБАН ШААРДЛАГА

1. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 1,164.0 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлага үүсгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

### 8.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1.Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал**

1.1 **Илрүүлэлт:** Аймгийн ТЕЗ буюу Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж, ажиллаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн

бодлогын баримт бичгийг ..., мөрдөж ажиллана” гэж заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:** Аймгийн Засаг даргын 2021 оны А/58 тоот захирамжаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллах.

## **2. Бараа материалтай холбоотой асуудал**

**2.1 Илрүүлэлт:** Тайлант онд худалдан авсан 12,065.2 мянган төгрөгийн шатахуун, сэлбэг хэрэгсэл, засварын материалыг бараа материалын дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.2-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө”, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын холбогдох заалтуудтай нийцээгүй бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**2.2 Өгсөн зөвлөмж:** Бараа материалыг тооцооны дансаар дамжуулан бүртгэж байх зөвлөмж хүргүүлэв.

## **3. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд**

**3.1 Илрүүлэлт:** Тайлант онд 4,566.4 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, засварын материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

**3.2 Өгсөн зөвлөмж:** Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх

#### **4. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал**

**4.1 Илрүүлэлт** Шилэн дансны цахим хуудсанд 7 мэдээллийг хугацаа хоцроож, 5 мэдээллийг огт мэдээлгүй байна.

**4.2 Өгсөн зөвлөмж:** Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.3, 6.4.5, 6.4.7 дахь заалтуудыг зөрчсөн байгаа тул холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс										
						Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж		
						Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Хүдэр тохижилт ОНӨААТҮГ	СЭА-2022/13/-НА-СТА-ОНА	ХХОАТ-ын авлага үүсгэсэн.	1	1,164.0						1	1,164.0				
2	Хүдэр тохижилт ОНӨААТҮГ	СЭА-2022/13/-НА-СТА-ОНА	НБББББ боловсруулж мөрдөөгүй	1											1	
3	Хүдэр тохижилт ОНӨААТҮГ	СЭА-2022/13/-НА-СТА-ОНА	Сэлбэг хэрэгсэл, засварын материалыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй	1	4,566.4										1	4,566.4
4	Хүдэр тохижилт ОНӨААТҮГ	СЭА-2022/13/-НА-СТА-ОНА	Бараа материалыг шууд зардлаар бүртгэсэн	1	12,065.2										1	12,065.2
				4	17,795.6						1	1,164.0			3	16,631.6
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
1	Хүдэр тохижилт ОНӨААТҮГ	СЭА-2022/13/-НА-СТА-ОНА	Шилэн дансанд 7 мэдээлэл хугацаа хоцроосон, 5 мэдээллийг огт мэдээлээгүй	1											1	
			<b>ДҮН</b>	<b>1</b>											<b>1</b>	
			<b>НИЙТ ДҮН</b>													

